

САРМИС

Ач холбогдол.



Эфирийн тос, амин дэм С, В, иодыг их хэмжээгээр агуулсан, зүрх судасны болон, мэдрэл, хоол боловсруулах эрхтэний үйл ажилгааг хэвийн байлгахад сайн нөлөөтэй.


Сорт: Улаан, цагаан хальст сортууд байдаг. Үүнээс улаан хальст сорт нь цагаан хальстай сортыг бодвол ургалтын хугацаа богинотой, илүү аагтай.

Ургах нөхцөл. Шим тэжээлийн бодисоор баялаг агаарын солилцоо сайн явагдадаг хөнгөн хөрс шаардана.


Хөрс боловсруулах. Хөрсийг урд намар нь 22 - 28 см гүн эргүүлж хагалаад элсэрхэг хөрсөнд 1 м² талбайд 3 - 5 кг, шавранцар хөрсөнд 2 – 2,5 кг бүрэн ялзарсан бууц орохоор тооцож бордоод бордоог сайн хольж хөрсөнд нь булж өвөлжүүлнэ. Бордоог сайн булахгүй бол түүний азот нь ууршиж алдагдах муу талтай.

Үрийг бэлтгэх. Өвчилж муудаагүй сармисыг сонгон авч гадна талын том хумснаас зөөлөрөөгүй жигд хэмжээтэйг нь ялган берзэнтэн дээр юмуу шуудайн дээр дэлгэж нарлуулна. Нарлуулах явцад 20 хэмийн бүлээн усаар өдөрт 3-аас доошгүй удаа жигд норгож тогтмол чийгэлж хутган хатсан үе нь усаар ширшинэ. Ийм байдлаар шөнөд нь хучиж өдөрт наранд ээн 1-2 хоног соёолуулна. Ингэхэд хумс жигд соёолохоос гадна үндэс нь ургаж эхлэнэ.

Тарилт. Сармисыг 4-р сарын 25-наас 5-р сарын 5ны хооронд тариална.



Талбайг 1,5м өргөнтэй хайрцаглан засна. Талбайн уртыг тухайн таримлын тарих хэмжээ, газрын гадаргуугын услах боломж зэргээс шалтгаалан сонгоно. Хэрэв хазгай газар бол талбайн хөрсийг өндөр талаас нь нам тал руу нь татаж хөндлөн чиглэлд тэгшилнэ. Тэгшилгээг жигд хийхгүй бол усалгааны ус жигд биш хуваарилагдаж болц гүйцэж хумслах явц удааширна.



Эгнээ хооронд 20см, ургамал хооронд 10см зайтайгаар хумсны үзүүрийг хөрсний гадаргуугаас 2-3см гүнд суулгана. Суулгасан хумсны тахир талыг умар зүг буюу нар ургах зүгрүү харуулна. Сармисны хумсыг дээр суулгавал соёолохоосоо өмнө хөрсөн дээр гарч ирдэг. Учир нь сармисны үндэс хөрсрүү ургахаасаа өмнө үрээ дээш нь түлхэж ургадаг.

Ээлжлэн тариалалт:



Усалгаа. Ургалтын хугацаанд 2-3 удаа 1 м^2 талбайд 30-40 литр ус орохоор тооцож усалгаа хийнэ. Анхны усалгааг тогтуун зөөлөн хийх. Сармисыг тариалсанаас хойш 14 хоноод дахин услаж хөрсийг сийрүүлнэ. Энэ үед соёололт нь бүрэн жигдэрсэн байдаг. Ургалтын хугацаанд хэт олон дахин уславал хортонд нэрвэгдэнэ.

Арчилгаа. Сармисны соёо цухуйж гарах үед нь хөрсний өнгөн үеийг сийрүүлж хог ургамлыг устгах явцдаа бага зэрэг маналт хийж өгнө. Хортонгоос сэргийлэхийн тулд 6-р сарын эхэн үеэс эхлэн 3-5 хоног тутам аргалын үнс пургиулна. Хортон илэрвэл тухайн үед нь үед хлорфостын 3%-ийн уусмалаар ширшинэ. Саримс тарьсан талбай үржил шим багатай бол ид ногоон масс ургах үед нь үхрийн шинэхэн баасны уусмалаар бордоно.



Усалгаа бүрийн дараа мөр хоорондын зайн хөрсийг сийрүүлж хөрсний агааржилтыг сайжруулах, зэрлэг усгах ажлуудыг хийнэ. 7-р сарын 2-р хагаст булцуу үүсгэх зорилгоор гол буюу цоорыг сугалж авна. 8-р сарын сүүлчээс эхлэн ишний ногоон массны шимийг булцуунд нь буулгах зорилгоор навчийг налуулна.

Хураалт. 1 м.кв талбайгаас 3кг ургац авна. Сармисны хураалтыг ишийг налуулсанаас 7-10 хоногийн дараа буюу хумс нь бүрэн хальсжсан үед хийнэ. Хурааж аваад 20-50 ширхэгээр нь багцлан шүлжин сүүдэр газар хатаах ба 3-7 хэмийн дулаантай хуурай зооринд хадгална.